



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/34

Мөрөн сүм

Г Ариутгал, халдвартгүйтгэл, сэг зэм
устгалын ажил зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн A/34 дүгээр тушаалын дагуу хүн, малын гоц халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа, байр, зоорь, агуулах, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх халдвартгүйтгэлийн ажлыг 2023 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 20-ний өдрийн дотор аймгийн хэмжээнд зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, машин техник, шатахуун бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), сумын Засаг дарга нар тус тус даалгасугай.

2. Ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, холбогдох тайлан мэдээг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэхийг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), ариутгал, халдвартгүйтгэлийн ажлын явц, чанар гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар, хэрэгжилтийн тайлан мэдээг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нар тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.



Захирамж-2023

6711010092